Golomt Capital®

Таваарын зах зээлийн долоо хоногийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.02.21

Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс

Golomt Capital®

НҮҮРСНИЙ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 02 сарын 21

Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн 7 хоногт БНХАУ-ын засгийн газраас таваарын бүтээгдэхүүний ханшийг тогтворжуулахаа мэдэгдсэнээр цахилгаан станцуудын нүүрсний агуулахын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг эрчимтэй авч байна. Тодруулбал, 2021.02.13-нд БНХАУ-ын China State Railway Corporation 91,000 галт тэрэг нүүрс тээвэрлэсэн нь бүх цаг үеийн амжилтыг эвдсэн юм.

Тухайн өдөр БНХАУ-ын 363 цахилгаан станцад 64.34 сая тонн нүүрс нийлүүлсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 53 хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн сүүлийн үед эрчим хүчний тогтвортой байдлыг хангах үүднээс Beijing-Tianjin-Hebei мужуудад нүүрсний нийлүүлэлтийг нэмэгдүүлээд байна.

Түүнчлэн шинэ уурхайн төслүүдэд хөрөнгө оруулалт идэвхтэй хийгдэж байна.
2021.02.15-нд БНХАУ-ын эрчим хүчний зохицуулагч байгууллагаас Shaanxi мужид 4.8 тэрбум юань /756 сая ам.доллар/-иар баригдах нүүрсний уурхайн төслийг баталжээ.

Тус уурхай нь жилд 3 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай юм.



БНХАУ нь 2030 онд агаарын бохирдлоо 60 хувь, 2060 онд агаарын бохирдолгүй болох гэсэн зорилтыг тавин ажиллаж байгаа ч эрчим хүчний асуудалтай холбоотойгоор нүүрсний нийлүүлэлтийг бууруулж чадахгүй байна.

Харин Монгол Улсын хувьд 2022 оны 1 сард нийт 2.03 сая тонн нүүрс олборлосон бөгөөд энэ нь оны мөн үеэс 55.85 хувиар бага сарын өмнөх үеэс 18.06 хувиар бага үзүүлэлт юм байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг яттасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Golomt Capital®

ТӨМРИЙН ХҮДРИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 02 сарын 21

Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн даваа гарагт БНХАУ-ын Далианы таваарын биржид арилжаалагдаж буй төмрийн хүдрийн 5 сарын гэрээний ханш 790 юань дээр нээгдэж, баасан гарагт 675 юань дээр хаагдсанаар 14.5 хувиар уналаа.

Өнгөрсөн долоо хоногийн баасан гарагт БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэчлэлийн хорооноос аж үйлдвэрийн салбарыг идэвхжүүлэх зорилготой бодлогын 18 арга хэмжээг хэрэгжүүлж байгаагаа олон нийтэд танилцуулав. Ялангуяа шинэ дэд бүтцийн ажлыг эрчимжүүлэхийн тулд түүхий эд материалын нийлүүлэлтийг сайжруулах замаар үнэ тогтворжуулах төлөвлөгөөтэй байгааг мэдэгдсэн юм.

Мөн дотоодын компаниудыг дэмжих үүднээс төмрийн хүдэр болон зэсийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах замаар хаягдал метал боловсруулалтыг эрчимжүүлэх зэрэг арга хэмжээг авахаар болжээ.

Засгийн газрын дээрх мэдээлэлтэй холбоотойгоор Далианы таваарын биржийн төмрийн хүдрийн ханш долоо хоногийн ханш сүүлийн хоёр жилийн хугацаан дахь өндөр уналтыг үзүүлсэн байна.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг яттасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Golomt Capital®

ЗЭСИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 2-р сарын 21

Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн даваа гарагт Шанхайн таваарын биржид арилжаалагдаж буй зэсийн 11 сарын гэрээний ханш 71,500 юань дээр нээгдэж, баасан гарагт 71,510 юань дээр хаагдсанаар тогтвортой байв.

Харин баасан гарагт БНХАУ-ын засгийн газраас дэд бүтцийн салбарыг эрчимжүүлэх зорилгоор таваарын бүтээгдэхүүнийн нийлүүлэлтийг сайжруулж ханшийг тогтворжуулах төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдсэн.

Мөн БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэчлэлийн хорооноос эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх үүднээс говь хээрийн бүс дэх салхин болон нарны томоохон цахилгаан станцуудыг барих төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдсэн байна.

Дэлхийн улс орнуудын хэрэгжүүлж буй сэргээгдэх эрчим хүчний шилжилт нь эрчим хүчний дамжуулагч дэд бүтцийн голлох түүхий эдэд ордог бүтээгдэхүүнүүдийн ханшийг урт хугацаанд өсгөх хөшүүрэг болоод байна.

Тиймээс БНХАУ-ын төрийн сан ханшийн өндөр өсөлттэй байгаа таваарын бүтээгдэхүүнүүдийг нийлүүлэх замаар ханшийн өсөлтийг барих бодлого баримталж байгаа юм.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг яттасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.